

АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 03 ДУГААР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны үйл ажиллагааны мэдээлэл

1. Хурлын хуралдааны талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 13 дугаар хуралдааныг 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдөр хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлэв.

1. 2022 оны шилжих үлдэгдлийг хуваарилан 2023 оны төсөвт зохицуулалт хийх тухай
2. Өмчийн тухай
3. “Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр батлах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

2023 оны 03 дугаар сарын 10-15-ны хооронд ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх танхим болон цахим хосолсон 40 цагийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж, сертификат авсан. Тус сургалтад ажлын албаны дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг 100% хамрууллаа. Мөн сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг тус сургалтад хамруулсанаас Хангай, Хашаат, Цахир, Тариат, Эрдэнэмандал, Эрдэнэбулган, Өгийнуур, Батцэнгэл сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар оролцоогүй байна.

Сургалтад хамрагдсан сумдын нарийн бичгийн дарга нарыг аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар хүлээн авч уулзаж цаг үеийн болон өдөр тутмын үйл ажиллагааны талаар зөвлөмж, чиглэл өглөө. Тус уулзалтад Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт П.Ганбат оролцож Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлого чиглэлийг танилцуулж санал хүсэлтийг сонсов.

2. Зөвлөл, хороодын ажлын талаар:

3 дугаар сард зөвлөлийн хурлыг 2 удаа, хороодын хурлыг 4 удаа зохион байгууллаа.

Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороог хуралдуулж "Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс" арга хэмжээний хөтөлбөр батлах тухай асуудлыг хэлэлцэн хорооны дүгнэлтийг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн.

Хууль эрхзүй, орон нутгийн өмч, өргөдөл гомдлын хорооны хурлыг ИТХ-ын иргэний танхимд цахимаар хийж дараах асуудлуудыг хэлэлцэн санал дүгнэлт боловсруулан аймгийн ИТХ-ын ээлжит бус 13 дугаар хуралдаанд хэлэлцүүлж батлууллаа.

Үүнд : Нэг. Орон нутгийн өмчөөс 2023 онд хувьчлах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай

Хоёр. Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн Уаз-220695 маркийн 22-37 Ара автомашин данснаас хасч сэлбэг болгон актлах тухай

Гурав. Эрдэнэ-мандал сумын Эрүүл мэндийн төвийн Уаз-220695-460 маркийн 33-65 Ара автомашин данснаас хасч сэлбэг болгон актлах тухай

Дөрөв. Аймгийн Цагдаагийн газраас аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашины граж шилжүүлэх тухай зэрэг асуудлыг хэлэлцсэн болно.

Ээлжит бус арван гуравдугаар хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөгдсөн “2023 оны Орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай” асуудлыг Төсөв санхүү, эдийн засаг хөгжлийн хорооны хурлаар хэлэлцүүлж санал дүгнэлтээ хүргүүлсэн байна.

3.Ажлын албаны үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын ээлжит бус 13 дугаар хуралдааны 11 тогтоолыг arkhangai.khural.mn цахим сайтад байршуулсан. Мөн Архангай амьдрал сонинд ээлжит бус хуралдааны тогтоолыг цахимаар хүргүүлсэн.

Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт khural.mn сайтын хөтлөлт хангалтгүй хөтлөж байгаатай холбогдуулан сум тус бүрийн мэдээ, судалгааг гарган ажил эрчимжүүлэх талаар 3 сарын 21-ны 34 тоот бичгээр чиглэл хүргүүлсэн.

БНСУ-ын Кёнги мужийн иргэдийн хуралд аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн урилгыг хүргүүлж, шаардлагатай байгаа 2ш галын машины дэмжлэг үзүүлэх хүсэлтийг хүргүүлэв.

БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яамны дипломат төлөөлөгчид Архангай аймагт хоёр өдрийн албан айлчлалтай холбогдуулан аймгийн ИТХ-ын дарга хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Аймаг сумдын ИТХ-ын Төлөөлөгч, 516 албан тушаалтны Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн /Хас-Хом/-ын бүрдүүлэлтийн 2022 оны тайланг холбогдох маягтаар гаргаж 19 сумаас авч нэгтгэн ИТХ-ын даргын № 26 албан тоотойр Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд нь хүргүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас бусад байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан 19-н албан бичгийг шивж, албажуулж хугацаанд нь хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын А/81 захирамжаар томилогдсон ажлын хүрээнд орон нутгийн өмчийн газраас 2023 оны 03-р сарын 03-ны өдөр Төвшрүүлэх сумын 2-р багийн төвийн барилга, Чулуут сумын халуун усны барилгын дуудлага худалдааг орон нутгийн өмчийн газартай хамтарч хуулийн хүрээнд зохион байгуулж, дуудлага худалдааг явууллаа.

“Архангай Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл” цахим хуудсанд 9 мэдээ, 4 контент, “Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” цахим хуудсанд 15 фото мэдээ, 2 үйл явцын мэдээ, 2 контент оруулан 20,246 хүнд хүрсэн байна.

4. Сургалт, мэдээлэл, сурталчилгаа:

Авлигатай тэмцэх газрын 03/3197 албан бичгийн хүрээнд цахимаар зохион байгуулж буй 21 аймгийн сургагч багш нарын нэгдсэн сургалтад оролцлоо.

3 дугаар сарын 14-ний өдөр “Монгол улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож удирдах нь” “Дотоод шилжих хөдөлгөөн”- Төрийн үйлчилгээний онцлог сэдэвт сургалтад ажлын албаны 3 албан хаагчийг хамруулсан.

Авилгатай тэмцэх газраас 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрт орсон өөрчлөлт цаашид хэрэгжүүлэх ажлын талаар 21 аймгийн ИТХ-ийн дарга, Засаг дарга, Хууль хяналтын байгууллагуудын оролцсон цахим сургалтанд хамрагдсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2022 оны санхүүгийн тайланд Аудит шалгалт хийгдэж холбогдох тайлан баримтыг гаргаж ажиллаа.

Салбар зөвлөлийн төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн салбар зөвлөлийн хуралдаанд оруулахад бэлэн болголлоо.

Нийгмийн даатгалын тайлан, шилэн данс, сарын мэдээг хугацаанд нь гаргаж, холбогдох гүйлгээг хийсэн.

Төсвийн тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын төсвийн сар, улирлын хуваарийг шинэчлэн боловсруулж санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

3-р сард дараах зардлууд гарсан:

- Томилолт- 192,000
- Шатахуун- 1000,000
- Тээврийн хэрэгслийн татварт-164,304
- Цалингийн урьдчилгаа-4,750,000
- Бусад зардалд-1,235,250

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай танилцаж, тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар санал солилцож, дэмжиж ажиллахаа илэрхийллээ. Уулзалтаар 14 суманд шүдний кабинет байгуулж, ард иргэдийн эрүүл байдлыг хамгаалах ЭРҮҮЛ ШҮД-АРХАНГАЙ төсөл, бүх суманд хавдрын эрт илрүүлгийн явуулын үзлэгийн багийг ажиллуулах ХАВДРЫН АЮУЛГҮЙ АРХАНГАЙ төсөл, бүх сумын эрүүл мэндийн төвийг боловсон 00-той болгох СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ САЙЖРУУЛАХ гэсэн төслүүдийг хэрэгжүүлж ажиллахаар Эрүүл мэндийн газрын даргад дээрх асуудлаар төсөл хүргүүлэх чиглэл өгсөн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус 13 дугаар хуралдаанаар Аймгийн Засаг дарга Б. Цэрэннадмид орон нутагт ажиллаж байгаа Төрийн захиргааны албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлэх, Ар Ус Ундарга ХХК-ийн хуримтлагдсан дамжуулан зээлдүүлсэн өр төлбөрөөс 550 сая төгрөгийг барагдуулах, Аймгийн түүхт 100 жилийн ой угтсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг эрчимжүүлж, хөрөнгийн тодорхой эх үүсвэрийг батлах зэрэг асуудлуудыг оруулж, шийдвэрлүүлээ.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотыг хамарсан "Хөдөөгийн сэргэлт" үндэсний чуулган 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр боллоо. Хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлэх Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, үзүүлж буй дэмжлэгийг иргэдэд танилцуулах зорилгоор энэхүү чуулганыг зохион байгуулж байгаа юм. Чуулганд аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, аймгийн ХХААГ, ГХБХБГ, БОАЖГ, зарим сумдын удирдлага болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчдийн төлөөллүүд оролцон орон нутгаа сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаши Хироюкитэй 2023 оны 03 дугаар сарын 13-нд Япон Улсын Засгийн газрын "Өвсний үндэс- Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж"-ийн хөтөлбөрийн төслийн гэрээнд гарын үсэг зурлаа. Төслийн хүрээнд Жаргалант сумын ЕБС-ийн байрны өргөтгөл, спорт заалны их засварын ажил хийгдэх юм. Гэрээ байгуулах үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, Жаргалант сумын ЕБС-ийн захирал Г.Мөнхтөр, нийгмийн ажилтан Д. Раднаасэд нар оролцлоо. Жаргалант сум нь аймгийн төвөөс алслагдсан, хамран сургах тойргийн хүүхэд олонтой, үйл ажиллагаа нь аймагтаа тэргүүнд байдаг сум юм.

Архангай аймагт 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамны дэд тэргүүн, элчин сайдын зөвлөх Жан Мүшин тэргүүтэй дипломат төлөөлөгчид албан айлчлал хийлээ. Архангай аймагт хийсэн хоёр өдрийн албан айлчлалын хүрээнд хамтын харилцаагаа хөгжүүлж, харилцан ашигтай, хамтдаа хөгжихөд тууштай хамтран ажиллах талаар санал солилцлоо.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн эхний үе шат "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилтыг төрийн албан хаагчдад танилцуулах сургалт Архангай аймагт 2023 оны 03 дугаар сарын 18, 19-ны өдрүүдэд боллоо. Сургалтад аймгийн ЗДТГ, төрийн албан хаагч, байгууллагын удирдлагууд, зарим сумдын ЗДТГ-ын албан хаагчид зэрэг 100 гаруй төрийн албан хаагч хамрагдаж, "Алсын хараа 2050" үзэл баримтлалд тусгагдсан Үндэсний нэгдмэл зүйл, Сайн засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Амьдралын чанар, Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил зэрэг сэдвийн хүрээнд суралцсан.

Архангай аймагт барилга, инженер, экологийн Зэвсэгт хүчний 342 дугаар анги шинээр байгуулагдаж барилгын шав тавих ёслол боллоо.

Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Архангай-100 БИДНИЙ ОРОЛЦОО тохижилтын аяныг ард иргэдийн санал санаачлагыг дэмжих, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгууллаа. Цахим орчиноор дамжуулан иргэдийн санаа бодлыг сонсох, шийдэл гарцыг хайх, харилцан мэдээлэл солилцож, үр дүнг нэгтгэж боловсруулснаар хэд хэдэн ажлыг зохион байгууллаа.

1. Тохижилтын аяны хүрээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэд, евро хашаа блок үйлдвэрлэдэг ААН, иргэд, хүнд машин механизм, ачаа тээврийн үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэд болон аймгийн төвийн

ойролцоох сумдын удирдлагууд, Эрдэнэбулган сумын иргэдийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд иргэд хямд үнэтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хашаа хороогоо сайжруулах гаргалгааг олж харсан бөгөөд элс хайрга, хоргын хүрмийг иргэд, ААН-д чирэгдэлгүй олгох ажлыг орон нутгийн удирдлага, экологийн цагдаатай хамтран шийдвэрлэхээр болов.

2. Аяны хүрээнд иргэд амьдрах орчноо сайжруулах, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн байх нь гол зорилго юм. Ийм учраас аймгийн Засаг дарга банкны салбарын удирдлагуудыг хүлээн авч уулзан, иргэдэд бага хүүтэй, шаардлага багатай хэрэглээний зээл гаргуулах тал дээр нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжиж ажиллахыг хүссэн. Банкны удирдлагууд хүсэлтийг дэмжиж, дээд шатны удирдлагууддаа уламжилж, хамтарч ажиллахаа илэрхийллээ.
3. Тохижилтын аяны нээлтийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр албан ёсоор эхлүүлж барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН байгууллага, иргэдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үзэсгэлэнг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг дэмжиж УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, БХ-ын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, Аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал, Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, төрийн байгууллагын ажилтан албан хаагчид, ард иргэд оролцлоо.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа 2050” урт хугацааны бодлого, “Хот, хөдөөгийн сэргэлт” дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Нээлттэй Архангай” хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон Архангай аймгийн түүхт 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд аймгийн Засаг даргын санаачилгаар “Архангай 100-Соёлын хөгжил”, “Архангай 100-Боловсролын хөгжил”, “Архангай 100-Эрүүл мэндийн хөгжил” форумыг 2023 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү 3 өдрийн форумд УИХ, ЗГ-ын гишүүд, холбогдох яамдын болон аймаг орон нутгийн удирдлага, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын албан хаагчид, эцэг эх, асран хамгаалагчид, суралцагчид, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн холбогдох ажилтнууд нийт 600 гаруй хүн оролцлоо.

“АРХАНГАЙ 100-СОЁЛЫН ХӨГЖИЛ” ФОРУМ- Архангай аймгийн соёлын салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, салбар хоорондын хамтын ажиллагаа, хөгжлийн гарцыг тодорхойлох зорилготой Соёлын хөгжил форум 3 дугаар сарын 27-ны өдөр боллоо. Тус форумд УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтыг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг тэргүүтэй ажлын хэсэг, сумдын соёлын төвүүд, аймгийн ХДТ, Музей, Номын сан, Гэрэл зурагчдын холбоо, Зураач урчуудын холбоо, соёлын бүтээл үйлдвэрлэгч иргэд зэрэг 200 гаруй хүн оролцов. Форумд оролцогчид салбарын өмнө тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн хэрхэн шийдвэрлэх, хэрэгжүүлэх санал зөвлөмжийг бодлого

боловсруулагчид, аймаг орон нутгийн удирдлага, соёлын байгууллагууд, иргэд олон нийт гэсэн түвшинд гаргаж баталлаа.

“АРХАНГАЙ 100-БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ” ФОРУМ- Боловсролын салбарын бүх шатны байгууллагын удирдлага, багш, ажилтан, албан хаагчид, сурагчид, тэдний эцэг эх, асран хамгаалагчид өөрсдийн хийх, хийж чадах зүйлийг тодорхойлж аймгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах зорилготой Боловсролын хөгжил форум 28-ны өдөр зохион байгуулагдлаа. Форумд УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, БЕГ-ын дарга Т.Ням-Очир, БСҮХ-ийн захирал М.Итгэл, БҮТ-ийн захирал Л.Ганбат, аймгийн БШУГ-ын дарга Ц.Мөнхбат, сумдын ЕБС-ын захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нар, багш, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөл 300 гаруй хүн оролцсон. Форумд оролцогчид “Мэдье-эрхэмлэе-дэмжье-суралцъя-хамтаръя” уриатай төрийн удирдлага, боловсролын удирдлага, багш, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид гэсэн түвшинд зөвлөмж уриалгыг баталлаа.

“АРХАНГАЙ 100-ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖИЛ” ФОРУМ- Эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлаар хамтын ажиллагааг сайжруулан, хөрөнгө оруулалт, хөгжлийг хангах гарцыг олох зорилготой Эрүүл мэндийн хөгжил форум 29-ний өдөр болж, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг, УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал, Засаг дарга Б.Цэрэннадмид, ЭМДЕГ-ын дарга Л.Бямбасүрэн, ЭМ-ын сайд асан А.Цогцэцэг, Цэргийн төв эмнэлэгийн дарга Б.Энх-Од, аймгийн ЭМГ, НЭ, ЗӨСТ, сумдын ЭМТ-ийн эрхлэгч, ахлах сувилагч нар, эмийн сан, хувийн эмнэлгийн төлөөлөл зэрэг 150 гаруй хүн оролцлоо. Форумын үеэр 11 сумын ЭМТ-д эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хөрөнгө оруулалт хийлээ.

Аймгийн түүхт 100 жилийн ойг угтаж Цэргийн төв эмнэлгийн “Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг”-ийн хөдөлгөөнт багийг 19 суманд ажиллуулах төсөл хэрэгжиж байна. Төслийн нээлт Төвшрүүлэх суманд болж, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид нар оролцож, үзлэгийн явцтай танилцлаа. Хөдөлгөөнт үзлэгийн баг Хашаат, Хотонт, Батцэнгэл сум гэсэн маршрутаар ажиллаж, ээлж солилцох юм байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсвийн орлого

2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн дүнгээр улсын төсвийн орлогод өссөн дүнгээр 469,140,600.00 төгрөг төвлөрүүлэхээс 522,135,800.00 төгрөг төвлөрүүлж, биелэлт 111,3 хувь, аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр 843,902,000.0 төгрөг төвлөрүүлэхээс 644,402,500.00 төгрөг төвлөрүүлж, биелэлт 76,4 хувь, сумын төсвийн орлогод өссөн дүнгээр 2723596,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3044311,0 мянган төгрөг төвлөрүүлж, биелэлт 111,8 хувь байна.

Тендер, худалдан авах ажиллагаа

2023 оны 03 сарын 09-ний өдрийн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2023 онд хувьчлах үл хөдлөх хөрөнгүүд болон актлах авто машинуудын материалыг бүрдүүлж хуралд оруулсан. 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 11 цагт Төвшрүүлэх, Чулуут сумдын 2 барилгын дуудлагын худалдааг хууль журмын дагуу зохион байгуулж орон нутгийн төсөвт 4,735,000 төгрөгийг төвлөрүүлэн ажиллаа.

2023 оны 3 дугаар сарын байдлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 2009.9 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ, Нэгдсэн эмнэлгийн захиалгаар 2638,7 сая төгрөгийн Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлийн төсөл, нийт 4648,6 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээний тендерийг зохион байгууллаа.

2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 150.0 сая төгрөгийн өртөг бүхий Хот тохижилт, үйлчилгээний газарт ковш, 138.3 сая төгрөгийн өртөг бүхий Цагдаагийн камержуулалтын тоног төхөөрөмжийн 2 төсөл арга хэмжээний тендерийн нээлтийг хийж үнэлгээ хийх шатанд байгаа бол 4360,6 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээний тендерийг зарласан байгаа болно.

Хөрөнгө оруулалт

2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 108,850,8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд 77,017,4 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4,278,3 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгийн их засвараар 1,664,1 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдсан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Гамшиг осол

2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 20 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бөгөөд объектын гал түймэр 14, зам тээврийн осол 3, эрэн хайх, аврах ажиллагаа 2, төөрсөн сураггүй болсон хүн 1 мал амьтны гоц халдварт өвчин 3, хүний гоц халдварт /Ковид-19/ өвчин 1 удаа тус тус гарсан байна. Дээрх аюулт үзэгдэл, ослын улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 510.0 сая төгрөгний хохирол учирч Онцгой байдлын газрын алба хаагчид 23 хүний амь нас, 1,3 тэрбум төгрөгний өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

2023 оны 03 дугаар сарын 09-ны өдөр Эрдэнэмандал, Батцэнгэл, Хашаат, Эрдэнэбулган сумдын нутгаар салхи 10-14 секунд, Төвшрүүлэх, Хашаат, Хотонт, Өлзийт болон бусад сумдаар 11-27 метр секунд хүрч салхины хурд аюулт үзэгдлийн хэмжээнд хүрсэн. Байгалийн аюулт үзэгдлийн улмаас төрийн болон хувийн өмчид **99.8** сая төгрөгийн хохирол учирч, амь насаа алдсан болон бэртэж гэмтсэн хүн байхгүй байна.

Гэмт хэрэг

2023 оны 03 дүгээр сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 102 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 24, хулгайлах гэмт хэрэг 37, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 17, малын хулгайн гэмт хэрэг 18, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 24, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 8, гэмт хэргийн илрүүлэлт 54.9 хувьтай байна.

Нийт 7565 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 7338 иргэнд 272135 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 362.7 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 32.4 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний хэлтсээс мөрдөгч, прокурорын тогтоолоор эрүүгийн 22 хэрэгт криминалистикийн шинжилгээ хийсэн байна. Мөрдөн шалгах бусад ажиллагаа болох цогцосны үзлэг-30, задлан шинжилгээ-29 тус тус хийж, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ-95, бусад төрлийн шинжилгээнээс 0-17 насны хүнд бэлгийн холбогдолтой шинжилгээ-4 тус тус хийсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээ

Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн хэмжээнд иргэдэд тоон гарын үсэг олгож, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023.03.25-ны байдлаар дараах бүртгэлийг хийж гүйцэтгэжээ.

- Төрсний бүртгэл – 158
- Овог эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 3
- Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 1
- Гэрлэсний бүртгэл - 36
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 5
- Үрчилсний бүртгэл - 1
- Нас барсны бүртгэл – 57
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 78
- Дахин олгосон – 27
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 138 бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 356 иргэн, хуулийн этгээдээс мэдүүлгийг хүлээн авч, бүртгэлийг хийж гүйцэтгэжээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл - 12
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 12
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл –15
- Худалдах худалдан авах гэрээ – 40
- Бэлэглэлийн гэрээ – 12
- Барьцааны эрхийн бүртгэл – 209
- Өв залгамжлал – 6

- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 17
- Лавлагаа – 5
- Бусад эрхийн бүртгэл – 12
- Хóóëü öÿíàèòóí áàèãóóèëääää íèéò 34 èàâèàääää äàðääí õ¿ðã¿ëñÿí áàéíà.

Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 2.254.448 тэмдэгтийн хураамжид 212.369 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 4.940.048 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр бүртгүүлсэн – 11
- Өөрчлөлт – 22

Тамганы хяналтын дугаар олгосон – 33 бүртгэл хийсэн.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Эрүүл мэнд

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгаас санаачлан "Эрүүл чийрэг эр хүн" эрэгтэйчүүдийн өдөрлөгийг зохион байгуулж:

-Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал

-Архи согтууруулах ундааны эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл сэдвийн хүрээнд өдөрлөгт хүрэлцэн ирсэн болон нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэлээ. Мөн "Эрэгтэйчүүдийн кабинет"-д үзүүлж байгаа тусламж үйлчилгээг танилцуулах, эрүүл зохистой хооллолт, эмчилгээний хоолны үзэсгэлэн гаргаж хамтран ажиллаа.

Монгол орон даяар хэрэгжүүлж байгаа зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхитэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх жилийн ажлын хүрээнд зохион байгуулж байгаа “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” уриан дор 3 сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 03 сарын 16-нд Архангай аймгийн иргэд, төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчдыг оролцуулан нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

2023 оны 03 сарын 13-ны өдөр JCI олон улсын залуучуудын байгууллага, JCI Их хүрээ салбар, Эрүүл мэндийн яамтай хамтран “АМЬДРАЛ БЭЛЭГ” төслийн хүрээнд Элэгний В, D вирүстэй болон вирүсийн шалтгаант хатуурал, элэгний хорт хавдартай иргэдэд болон тэдний гэр бүлийнхэнд энэхүү өвчний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, сэтгэлзүйн талаас хэрхэн даван туулах, эрүүл мэндийн болон сэтгэлзүйн сургалт мөн тус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар цогц мэдээлэл өгөх сургалтыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан. Тус сургалтанд Эрдэнэбулган сумын 68 иргэн оролцон эрүүл мэндийн мэдлэгээ дээшлүүллээ.

Эрүүл мэндийн газрын “Ирээдүйн босго-Өсвөр үеийн эрүүл мэндийн төв”-өөс Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн 6-7-р ангийн 253 сурагчдыг “Өсвөр нас түүний онцлог” сэдвээр сургалтанд хамруулан, сурагчдын эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүллээ.

ЭМГ-ын даргын 2023 оны А/03 тушаалын дагуу Цэнхэр, Жаргалант сумын ЭМТ-ийн 2 сувилагчийг НЭ-ийн ЯТТ, Дотор, Хүүхэд, Цусны салбар төвд 14 хоног ажлын байранд дадлагажуулан сургав.

ЭМГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаал, удирдамжийн дагуу Хангай, Цахир, Тариат, Өндөр-Улаан, Ихтамир, Чулуут, Өгийнуур, Хашаат, Төвшрүүлэх, Цэнхэр сумдын зуд гамшгийн үеийн эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, тасралтгүй байдал болон отор нүүдлээр яваа иргэдийн эргэлт хяналт, тусламж үйлчилгээний бэлэн байдалд газар дээр нь үнэлгээ хийн, эмч ажилчдад сургалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

2023.03.28-ны байдлаар коронавируст халдварын батлагдсан тохиолдол гараагүй. Түргэвчилсэн шинжилгээнд 1670 хүн, сүүлийн 7 хоногт 112, ПСР шинжилгээнд 134 хүн, сүүлийн 7 хоногт 2 хүн хамрагдсан байна. Вакцинжуулалтанд:

1-р тунд 60929 хүн буюу 87.89 хувь /12-с дээш нас/

2-р тунд 57661 хүн буюу 83.28 хувь /12-с дээш нас/

3-р тунд 27389 хүн буюу 50.12 хувь /18-с дээш нас/

4-р тунд 2524 хүн буюу 5.78 хувь /18-с дээш нас/

Соёл

Монгол Улсын Соёлын Сайдын А/34 тоот тушаалаар Улс орон даяар 03-р сарын 01-ны өдрөөс 05-ны өдрүүдэд "МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨР" арга хэмжээг зохион байгуулж, тус музейгээр том хүн 471, хүүхэд 1275, оюутан 49 нийт 1795 иргэд үйлчлүүлэн өв соёлтой танилцлаа. Музейн нээлттэй өдрүүдийн хүрээнд Улаанбаатар хотын Хан Уул дүүргийн Ерөнхий боловсролын 130-р сургуулийн 3д ангийн 41 сурагчийг цахимаар музей үзүүлж, Архангай аймгийн онцлог үзмэр, үүсэл хөгжлийн талаар болон Заяын хүрээний талаар мэдээлэл өгч, "Бидний мэдэх музей" сэдэвт боловсролын ажлыг зохион байгууллаа.

МУБИС-ийн харьяа Архангай аймаг дахь Багшийн сургуулийн Багын багшийн 1-р курсийн 45 оюутнууд дунд Үндэсний түүх, соёл, өв уламжлал, ёс заншлаараа бахархах, хүндэтгэн дээдлэх үзэл санааг бий болгох зорилготой "Үндэсний түүх, өв соёл мину" үйл ажиллагааг зохион явууллаа..

Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулан сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилгоор “ Уран жиргээ-2023 “ хүүхдийн яруу найргийн уралдааныг ХДТ-ын хамт

олон зохион байгууллаа. Уралдаанд сургуулийн өмнөх насны болон ЕБС-ийн 151 оролцогч оролцон авьяас чадвараа сорилоо.

Иргэдэд соёлын салбарын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ мэдээлэл хүргэх Ag.mos.gov.mn вэбсайтаар 15000 иргэд зочилж үйлчлүүлжээ.

Нийтийн номын сангаар нийт 158 уншигч шинээр бүртгүүлж, 2479 уншигчдад 3654 ном, хэвлэлийн бүтээгдэхүүн олгон, мэдээллийн үйлчилгээг хүргэж ажилласан. ЕБС-ийн бага, дунд бүлгийн болон цэцэрлэгийн 3-5 насны нийт 126 хүүхдүүдэд байгальд ээлтэй “Эко” танхимын үйл ажиллагаатай танилцуулан 130 номоор үйлчилсэн. Цэцэрлэгийн 3-5 насны хүүхдэд зориулсан “Их мэдэх” танхимаараа 96 хүүхэд, 10 багшид үлгэр, танин мэдэхүйн 200 номоор үйлчилгээ үзүүлсэн.

Нийтийн уншлагын танхимд, шинэ ирсэн 94 ширхэг ном болон цэргийн ШУ-ны 6 ширхэг номыг танилцуулах үзэсгэлэнг гаргалаа. Хүүхдийн уншлагын танхимд хүүхдийн танин мэдэхүй, уран зохиолын боловсролд зориулсан 150 ширхэг ном, цэрэг, эх орны сэдэвт 25 ширхэг номоор тус бүр шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, чөлөөт сонголтын хэлбэрээр танхимаар болон гэрээр олгон үйлчиллээ. Нийт 275 номоор үзэсгэлэн гаргаж, 1200 уншигчдад сонирхуулан оюуныг мялаалаа.

Боловсрол

Насан туршийн боловсролын төв нь 03 дугаар сарын байдлаар нийт 38 удаагийн сургалтыг 1053 иргэдэд зориулан зохион байгуулсан байна. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг дүгнэж үзвэл ёс зүй, ёс суртахууны үндсэн ойлголт, цаг төлөвлөлт ба бүтээмж, хувь хүний хөгжил, эр хүн таны хөгжилд, сэтгэл зүйгээ удирдах чадвар, байгууллагын цахим хуудас хөтлөлт зэрэг хичээлийг сонирхон судалж байна.

Нийгмийн хамгаалал

Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын санд 2023 оны 3 дугаар сарын байдлаар нийт 3.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 103 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 16.1 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 16,3 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 161.8 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

03-р сарын 21-ны өдөр “Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох” сэдвээр тэтгэврийн байцаагчтай хамтран хэлтсийн пэйж хуудсаар шууд дамжуулалт хийж иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

Пэйж хуудсанд 2023.03.23-ны байдлаар 38 мэдээ боловсрууж давхардсан тоогоор 25165 даатгуулагчдад мэдээллийг хүргэсэн бол 2269 даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар дараах ажлыг хийж гүйцэтгэжээ.

1. Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформд ажил идэвхтэй хайгч 520 иргэн бүртгэлтэй байгаагаас 267 эмэгтэй байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 36, зуучлал 10 байна. Тухайн сард ажил хайгчаар бүртгүүлсэн 41 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформд бүртгэлээ. Ажил идэвхтэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилбал: боловсролгүй- 11, бага- 46, суурь-88, бүрэн дунд-243, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 29, тусгай мэргэжлийн дунд- 14, Дипломын бакалаврын-89 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна.
2. Архангай аймагт барилга, инженер, экологийн Зэвсэгт хүчний 342 дугаар анги шинээр байгуулагдаж, ажилд орохоор бүртгүүлсэн 134 ажил хайгч иргэдэд ажлын байранд зуучлах, зөвлөгөө мэдээлэл өгөх уулзалт арга хэмжээг зохион байгуулсан.
3. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд нь зориулж 4 төсөл арга хэмжээг сонгон шалгаруулан 1,5-2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр болсон байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Энэ онд 19 сумын 101 багийн 8207 хот айлд 19.4 мянган малчин болон мал бүхий өрхийн 5,9 сая толгой мал өвөлжиж хаваржиж байна. Мэдээгээр нийт мал сүргийн 1.5 хувь нь хорогдсон. Үүнээс: Тэмээ-8 толгой буюу 0,46%, Адуу- 5679 толгой буюу 1,2%, Үхэр- 17216 толгой буюу 2,1%, Хонь-36168 толгой буюу 1,1%, Ямаа-31966 толгой буюу 2,0 % хорогдсон. Нийт мал сүргийн 2 хувь буюу 91037 толгой мал хорогдсон.

Төл бойжилтын мэдээг 2023 оны 03 сарын 08-наас 7 хоног бүр авч өнөөдрийн байдлаар нийт 27328 толгой эх мал төллөснөөс 3285 төл хорогдож, 24043 төл бойжиж, 88%-тай байна. Аймгийн дүнгээр нийт төллөвөл зохих хээлтэгчийн 1,2% төллөсөн.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран хэрэгжүүлж буй “Зудын эрсдэлийг эртнээс бууруулах хамтарсан тусламж-2023” төслийн тусламжийн багцыг өвөлжилт хүндрээд буй Хангай, Цахир, Өгийнуур, Хашаат сумдын 40-с доош настай, хонин толгойд шилжүүлснээр 300-с доош толгой малтай өрх толгойлсон малчин эмэгтэй, эрэгтэй, залуу малчин бүхий (нэг сум 10 өрх) 40 өрхөд хүргэх ажлыг зохион байгууллаа. Тусламжийн багцад 300 мянгаас 750 мянга хүртлэх бэлэн мөнгө, НҮБ-ын Хүн амын сангаас охид эмэгтэйчүүдийн багц, “Амин тун” бэлдмэл 3 кг, өвөл, хаврыг өнтэй давах зөвлөмж, малчны жаргалан ном, малчдад өгөх зөвлөмж, 10000 төгрөгний нэгж багтсан.

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр шийдвэрээр өвөлжилт хүндэрсэн 10 суманд 80 тн овьёос болон улаан буудайн холимог тэжээлийг хуваарилсан бол 9 суманд 61,3 тн тэжээл, аймгийн Засаг

даргын шийдвэрээр малчдад 10,3 тн тэжээлийг хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан. Мөн улсын нөөцийн салбараас 285 тн тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон. Аймгийн нөөцийн 150 тн өвс, 50 тн тэжээлийг хаваржилт хүндэрсэн 8 суманд олголоо. Мөн Улаан загалмайн нийгэмлэгээс 10 сумын 500 өрхөд тусламжийн багцыг тус тус олгосон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгосон 9.8 сая төгрөгийн шатахууны дэмжлэгээс 19 сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг орон нутаг, багт ажиллахад зориулан тус бүр 300.000 мянган төгрөгийн шатахууныг олгосон.

Одоогийн байдлаар сумын нөөцөд 85 тн өвс, ногоон тэжээл, 64,7 тн тэжээл байна. Аймгийн аюулгүйн нөөцөд өвс тэжээлийн үлдэгдэлгүй байна.

Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас малын хөлийн татварын орлогоос 60 тонн тэжээлийг худалдан авч малчин мал бүхий иргэдэд тараахад бэлэн болоод байна. Мөн шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах өвчнөөр эрт илрүүлгийн үзлэгийг 12 айлын 250 (бог 200, бод мал 50) малд хийсэн.

Өвөрхангай аймгийн 8 өрхийн 4619 толгой мал, Завхан аймгийн 22 өрхийн 10209 толгой мал, Говь-Алтай аймгийн 1 өрхийн 111 толгой мал, Баянхонгор аймгийн 3 өрхийн 831 толгой мал, Увс аймгийн 1 өрхийн 1005 толгой мал тус тус отроор хаваржиж байна. Нийт 35 өрхийн 20775 толгой мал хаваржиж байна.

Хашаат, Өгийнуур, Хотонт, Цахир, Цэцэрлэг сумдын 55 өрхийн 18,4 мянган толгой мал Булган, Төв, Дорнод, Хэнтий, Хөвсгөл аймагт отроор хаваржиж байна.

Газар тариалан

Хаврын тариалалтад шаардлагатай 1382,1 тн үр, 283,5 тн шатахуун, 10,8 тн бордоо, 1,7 мянган литр ургамал хамгааллын бодис, 100 морины хүчтэй трактор-1, 100 морины хүчтэй тракторт таарах хаман боогч-1, 75 морины хүчтэй трактор-1, 75 морины хүчтэй тракторт таарах хаман боогч-1, хаман боогч, хуйлан боогч, хор бордоо цацагч, комбайн тус бүр-1, зуны нийлэг хальсан хүлэмж 32 ширхэг, хүлэмжийн нийлэг хальсан хучлага 17 ширхэг, жимс, жимсгэнийн суулгац 14284 ширхэг, төмс, хүнсний ногооны 10,0 мянган кг үр, тэжээлийн ургамлын 147 тн үр, тосны ургамлын 7,3 тн үрийн захиалгыг нэгтгэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон хөдөө аж ахуйг дэмжих санд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд төмс, хүнсний ногооны 1751 тн-ийн багтаамжтай 37 энгийн зоорь, 698 тн-ийн багтаамжтай 80 нүхэн зоорь, 276 тн-ийн багтаамжтай 7 механикжсан хөргөлттэй агуулах, нийт 2725 тн-ийн багтаамжтай 124 зоорь, агуулах байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга байгууламж, дэд бүтэц

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас 2023 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22

төсөл арга хэмжээний зургийн болон ажлын даалгаварыг боловсруулан аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

Газрын биржийн цахим систем /mle.mn/-ээр 03 дугаар сарын байдлаар Эрдэнэбулган, Тариат, Хайрхан, Цахир, Эрдэнэмандал, Хотонт, Өлзийт, Өндөр-улаан, Булган, Ихтамир сумдад 91 байршилд 64.8га, төсөл сонгон шалгаруулах зарчмаар олгохоор Эрдэнэбулган, Хотонт, Тариат, Хайрхан, Булган сумдад 12 байршилд 11.0га газрыг газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулахаар олон нийтэд нээлттэй зарлан нийтэлсэн.

Архангай аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр 50-н арга хэмжээний 108,850,8.0 төгрөгийн хөрөнгө оруулалт, аймаг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 48-н арга хэмжээний 5,932,432.0 төгрөгийн хөрөнгө оруулалтууд тус тус хийгдэнэ.

Архангай аймагт барилга, инженер, экологийн зэвсэгт хүчний 342 дугаар ангийн барилга байгууламжийн БЭЗ-01 дугаартай Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгов.

Эрдэнэмандал сумын 104/2023 дугаартай магадлалын дүгнэлтээр батлагдсан “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах, зөвлөх үйлчилгээний ажлыг 2023 оны 03 дугаар сарын 03 өдрийн газрын даргын А/15 тушаалаар томилогдсон ЗТХА комисс хүлээн авав.

Аймгийн 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруултанд тусгагдсаны дагуу нийт 14 ажлын болон зургийн даалгавар боловсруулсан байна

- ✓ Хотонт сумын сургуулийн их засвар – 40,0 сая
- ✓ Өгийнуур сумын 50 тн хүнс ногооны зоорь – 110сая
- ✓ Ихтамир сумын эрүүл мэндийн төвийн засвар – 20,0сая
- ✓ Ихтамир сумын соёлын төвийн засвар – 20,0 сая
- ✓ Ихтамир сумын ЕБС-ын засвар – 50,0 сая
- ✓ Ихтамир сумын арьс шир боловсруулах цэг – 140 сая
- ✓ Чулуут сумын эрүүл мэндийн төвийн уурын зуухны засвар – 70,0 сая
- ✓ Өндөр-Улаан сумын ЕБС-ын засвар – 30 сая
- ✓ Өндөр-Улаан сумын үерийн далангийн ажил – 100 сая
- ✓ 6 дугаар багийн ЕБС-ын спорт заалны барилгын халаалтын засварын ажил – 50,0 сая
- ✓ Булган сумын мал нядалгааны цэг – 350 сая
- ✓ Хашаат сумын махны хөргүүрийн барилга – 300 сая
- ✓ 6 дугаар багийн мал нядалгааны цэг – 400 сая
- ✓ Цэцэрлэг сум эрүүл мэндийн төвийн засвар – 66,1 сая

Байгаль орчин

Байгаль орчин аялал жуулчлалын газар, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Өгийнуур сумын ЗДТГазартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 19-ны өдрүүдэд Өгий нуурт 36 ажилтан албан хаагч

ажиллалаа. Тус ажлын хүрээнд Өгийнуур орчмын эрэг дагуу үйл ажиллагаа явуулж буй гэр баазуудын 30 нүхэн жорлонг буулгаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийж, хог хаягдал түр хадгалах 6 цэгийг цэвэрлэж 8 тонн хогийг хогийн цэгт ачиж зайлуулсан. “ Өгий цом 2023 “ загасчлалын тэмцээний үеэр нуурийн мөсөн дээр авто машин байрлуулахгүй, машинтай зорчихгүй байх талаар хяналт тавьж ажилласан байна.

"JCI" Их Хүрээ байгууллагын хэрэгжүүлж байгаа MIND UPDATE төслөөс 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдөр Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургуулийн 11,12 дугаар ангийн сурагчдад зориулж Эх дэлхийн эзэн нь болоход хөтөлж "Ногоон Ирээдүй" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд оролцсон 450 гаруй сурагчдад Эх дэлхий, байгаль орчиндоо хайртай байх, мод тарихын ач холбогдол сэдвээр мэдээлэл хийлээ. "JCI" Их Хүрээ салбар байгууллагаас 1000 ширхэг модны суулгацыг үнэ төлбөргүйгээр хандивлаж, сурагчдыг байгаль орчноо хайрлан мод тарьж, арчлан ургуулахад идэвхтэй оролцохыг уриаллаа.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----